



Барилга угсралт, их засварын ажил 2021 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 3.2 их наяд төгрөг болж, 3.1 (97.3%) их наяд төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 87.1 (2.7%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна



Барилга угсралт, их засварын ажил 2021 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 668.9 (17.2%) тэрбум төгрөгөөр буурахад дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 670.9 (17.6%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн.

Барилга угсралт, их засварын ажил, гүйцэтгэгчийн төрлөөр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар /тэрбум төгрөг/



Дотоодын барилгын байгууллагаас хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 526.5 (15.6%) тэрбум төгрөгөөр, төрийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 253.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 118.5 (31.9%) тэрбум төгрөгөөр, гадаадтай хамтарсан байгууллагын барилга угсралт, их засварын ажил 33.9 тэрбум төгрөг болж, 25.9 (43.3%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.





Энэ оны эхний 9 сарын байдлаар барилга угсралт, их засварын ажлын 33.8 хувийг орон сууцны бус барилга, 32.8 хувийг орон сууцны барилга, 30.9 хувийг инженерийн барилга, байгууламж, 2.5 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оны мөн үеэс орон сууцны барилгын ажлын эзлэх хувь 2.6 нэгж хувиар өссөн бол орон сууцны бус барилгын эзлэх хувь 1.7 нэгж хувиар, инженерийн барилга, байгууламжийнх 0.5 нэгж хувиар, их засварын ажлынх 0.4 нэгж хувиар тус тус буурсан байна.




**Барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил, төрлөөр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар /тэрбум төгрөг/**

**БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ /ХУВИАР/**






**Орон сууцны бус барилга, төрлөөр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар /тэрбум.төгрөг/**



Орон сууцны бус барилгын ажлын гүйцэтгэл 2021 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 293.4 (21.2%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд, сургууль, соёлын барилгынх 166.7 (39.5%) тэрбум төгрөгөөр, бусад барилгынх 121.4 (45.1%) тэрбум төгрөгөөр, эмнэлгийн барилгынх 20.0 (31.1%) тэрбум төгрөгөөр, худалдаа, үйлчилгээний барилгынх 15.4 (16.3%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

**Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил, жил бүрийн эхний 9 сарын байдлаар /тэрбум төгрөг/**




Улаанбаатар хотод 2021 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.2 их наяд төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн нь улсын дүнд 37.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 4.2 нэгж хувиар буурсан. Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2021 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр Өмнөговь аймагт 964.3 тэрбум төгрөг, Дорноговь аймагт 272.2 тэрбум төгрөг болж, энэ нь аймгуудын барилга угсралтын ажлын дүнд 63.3 хувийг эзэлж байна. Эдгээр аймгийн нутаг дэвсгэрт төмөр замын болон газрын тосны үйлдвэрийг дагасан барилга угсралтын ажил эрчимтэй явагдаж байна.

Эх сурвалж: ҮСХ, Барилга байгууламж, объектын улирлын мэдээ (ББО-1)



## БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, ДОТООД, ГАДААДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГААР /ТЭРБУМ ТӨГРӨГ/ 2010-2020 он



Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4.7 их наяд төгрөг болж, 2016 оноос 1.3 (39.9%) их наяд төгрөгөөр өссөн бол 2019 оноос 175.4 (3.6%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Барилга угсралт, их засварын ажлын 97.6 хувийг дотоодын, 2.4 хувийг гадаадын барилгын байгууллага 2020 онд гүйцэтгэсэн нь 2016 оноос дотоодын барилгын байгууллагынх 7.3 нэгж хувиар өсөж, гадаадын барилгын байгууллагынх 7.3 нэгж хувиар буурсан байна.